

## 8 ТҮҮНИЙ ДҮР ТӨРХТЭЙ АМЬДРАЛ

### 8.1 БУРХАН БА АМИЙН АМЬСГАЛ

<sup>4</sup>ЭЗЭН Бурхан тэнгэр газрыг бүтээсэн тэр цагт тэнгэр газар бүтээгдсэн нь ийн болой. <sup>5</sup>ЭЗЭН Бурхан газар дэлхий дээр хур бороо оруулаагүй, газар хагалах хүн байгаагүй учир хээр талд мод бут хараахан байхгүй, тариалах талбайд ургамал ногоо арай ургаагүй байжээ. <sup>6</sup>Газар дэлхийгээс манан будан хөөрч, бүх газрын гадаргууг услав. <sup>7</sup>ЭЗЭН Бурхан тоос шорооноос хүнийг бүтээж, амин амьсгалыг хамраар нь үлээж оруулахад, хүн амьд оршигч болжээ.

<sup>8</sup>ЭЗЭН Бурхан дорно зүгт Еденд цэцэрлэг байгуулаад, тэнд өөрийн бүтээсэн хүнийг авчирч тавьжээ. <sup>9</sup>ЭЗЭН Бурхан тэнд янз бүрийн моддыг ургуулсан нь харахад үзэсгэлэнтэй, идэхэд сайхан байв. Тэр цэцэрлэгийн гол дунд бас амин мод хийгээд сайн мууг мэдүүлэгч мод байжээ. ( Эхлэл 2:4-9АБ 2004 )

[ ] Та үүрд мөнх үргэлжлэх зүйлийн төлөө ажилладаг уу?

[ ] Хүслийнхээ дагуу Тэр ямар ч үед амийг булааж авах хүчтэй гэдэгт та итгэдэг үү?

### 8.2 БУРХАНЫ ДҮР ТӨРХ

<sup>26</sup>Тэгээд Бурхан -Бид Өөрсдийнхөө дүр төрхийн дагуу Өөрсөдтэйгөө адилхан хүнийг бүтээж, далайн загас, огторгуйн шувууд, мал адгуус, бүх газар дэлхий, газраар мөлхөгч бүгдийг тэдэнд захируулья хэмээн айлдав. <sup>27</sup>Тэгээд Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээж, Бурханы дүр төрхөөр эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээв. ( Эхлэл 1:26-27 АБ 2004 )

[ ] Та өөрийгөө Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн гэдэгт итгэдэг үү?

[ ] Таны хувьд “Бурханы дүр төрх” нь ямар утгатай вэ?

[ ] Бүх амьд хүмүүс Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн бөгөөд Бурханы хүүхэд болох боломжтой гэдэгт та итгэдэг үү ?

### 8.3 ЕРӨӨЛ БА ДУУДЛАГА

<sup>28</sup>Бурхан тэднийг адислаж, тэдэнд -Өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэн, газрыг эзэмш! Далайн загас, огторгуйн шувууд хийгээд газар дэлхий дээр хөдөлдөг бүх амьтдыг захир хэмээн айлдав. <sup>29</sup>Бурхан -Газар дэлхий дээрх үрт ургамал, үрт жимсний мод бүгдийг Би та нарт өгнө. Тэр бүхэн та нарын хоол хүнс болно. <sup>30</sup>Газар дэлхий дээрх бүх зэрлэг араатан, огторгуйн бүх жигүүртэн шувууд, газраар мөлхөгч амьтай бүхэн, аливаа амьтдад ургамал ногоо бүгдийг хоол хүнс болгон өгнө хэмээв. Тэгээд тэр нь ёсоор болжээ. <sup>31</sup>Бурхан Өөрийнхөө бүтээсэн бүгдийг харахад нэн сайхан байжээ. Үдэш болоод, өглөө болов. Тэр нь зургаа дахь өдөр болой. ( Эхлэл 1:26-31 АБ 2004 )

<sup>1</sup>Ийнхүү тэнгэр газар, бүх юмс бүрэлдэн тогтжээ. <sup>2</sup>Долоо дахь өдөр болоход Бурхан Өөрийн хийж бүтээсэн ажлаа дуусгаж, хийж бүтээсэн ажил нь дууссан учир долоо дахь өдөртөө Тэрээр амарчээ. ( Эхлэл 2:1-2АБ 2004 )

[ ] Та Бурханы ерөөгдсөн зам дээр явж байгаа гэдэгт итгэдэг үү?

#### 8.4 ТӨГС ХҮЧИТ

<sup>6</sup>ЭЗЭН, Израилийн Хаан, түүний Чөлөөлөгч, түмэн цэргийн ЭЗЭН айлдаж байна. “Би бол эхэн, Би бол эцэс.Надаас өөр Бурхан байхгүй. ( Иса 44: 6 АБ 2004 )

<sup>8</sup>Хэдийгээр нүдтэй боловч сохор, чихтэй боловч дүлий хүмүүсийг авчрагтун. <sup>9</sup>Ард түмнүүд хуран чуулж бүх үндэстэн хамт цуглалаа. Тэдний дундаас хэн үүнийг зарлаж, урьдын юмсыг бидэнд тунхаглаж чадах юм бэ? Тэд зөвтгөгдөж болохоор өөрсдийн гэрч нарыг авчраг. Тэд сонсоод “Энэ бол үнэн” гэдгийг хэлэг. <sup>10</sup>“Та нар бол Миний гэрч нар” гэж ЭЗЭН айлдаж байна. “Та нар бол Миний зарц нар. Та нар мэдэж, Надад итгэж, Намайг Тэр мөн гэж таниасай гэсэндээ Би та нарыг сонгосон. Надаас өмнө бий болсон Бурхан байгаагүй бөгөөд Миний дараа ч байхгүй. <sup>11</sup>Би, зөвхөн Би бол ЭЗЭН мөн бөгөөд Надаас өөр аврагч байхгүй. <sup>12</sup>Зарлан хэлж, аварсан, тунхагласан нь Би билээ. Та нарын дунд ямар ч харийн бурхад байхгүй. Иймээс та нар Миний гэрч мөн” гэж ЭЗЭН айлдаж байна. “Би бол Бурхан. <sup>13</sup>Өнө мөнхөөс Би бол Тэр

юм. Миний гараас аварч чадах хэн ч байхгүй. Би үйлдвэл, хэн үүнийг зогсоож чадах вэ?”. ( Иса 43: 8-13 АБ 2004 )

- [ ] Христ бол цорын ганц Аврагч бөгөөд Эзэн гэдэгт та итгэдэг үү?
- [ ] Бурхан танд Христ дотор эрх мэдэл өгсөн гэдэгт та итгэдэг үү?
- [ ] Та өөрийгөө Бурханы гэрч гэдэгт итгэдэг үү?

## 8.5 ЭЗЭН БОЛ ГАНЦ

<sup>1</sup>Энэ бол Иорданыг гатлан очоод, эзэмших газар нутаг дээрээ та нарын дагаж мөрдөх тушаал, хууль, зарлиг бөгөөд үүнийг та нарт зааж сургахыг ЭЗЭН Бурхан чинь надад тушаасан юм. <sup>2</sup>Ингэснээр чи болон чиний хүү, ач хүү чинь насан туршдаа ЭЗЭН Бурханаасаа айн эмээж, миний та нарт тушаасан бүх зарлиг тушаалыг даган мөрдөх бөгөөд чи урт наслах юм. <sup>3</sup>Израиль аа, сонс! Та нар түүнийг дагаж мөрдөхдөө болгоомжтой бай! Тэгвэл чи сайн сайхан явж, өвөг дээдсийн чинь Бурхан ЭЗЭНий чамд амласанчлан чи сүү, балаар бялхсан тэр газар нутаг дээр улам өнөр өтгөн болно.

<sup>4</sup>Израиль аа, сонс! ЭЗЭН бол бидний Бурхан, ЭЗЭН бол ганц. ( Дэд хууль 6:1-4 АБ 2004 )

<sup>29</sup>Есүс -Эхнийх нь “Сонс, Израиль аа! Бидний Бурхан Эзэн бол ганц Эзэн мөн. ( Марк 12:29 АБ 2004 )

- [ ] Танд Түүний тушаал, зарлиг, хууль бий юу?
- [ ] Та боломжтой үедээ хүүхдүүддээ Бурханы үгийг заах уу?
- [ ] Та Их Эзэнийг Ганц гэдэгт итгэдэг үү?

## 8.6 БУРХАН БОЛ ХАНГАГЧ: ХАЙР ДАХЬ ХАЛАМЖ

<sup>8</sup>ЭЗЭН Бурхан-Хүн ганцаараа байх нь сайн биш учир Би түүнд тохирох туслагчийг бүтээе хэмээн айлджээ. <sup>19</sup>ЭЗЭН Бурхан шороогоор хээр талын янз бүрийн зэрлэг араатан, огторгуйн янз бүрийн жигүүртэн шувуудыг бүтээж, Адам тэдгээрийг хэрхэн яаж нэрлэхийг үзэхээр тэднийг түүнд авчирч өгчээ. Тэгээд Адамын амьтан бүрд өгсөн нэр нь тэдний нэр болжээ. <sup>20</sup>Тэгээд Адам бүх мал адгуус, тэнгэр огторгуйн жигүүртэн шувууд, хээр талын бүх зэрлэг араатанд нэр өгчээ. Харин Адамд тохирох туслагч олдсонгүй. <sup>21</sup>ЭЗЭН Бурхан Адамыг гүн нойронд автуулж, түүнийг унтаж байх зуур хавиргаас нь нэгийг сугалж аваад,

ормыг нь махаар бөглөжээ. <sup>22</sup>ЭЗЭН Бурхан Адамаас авсан тэр хавиргаараа эмэгтэй хүн бүтээгээд, түүнийгээ Адамд авчирч өгөв ( Эхлэл 2:18-22 АБ 2004 )

<sup>23</sup>Адам -Энэ бол яснаас минь авсан яс,  
Махнаас минь тасалсан мах бөгөөд  
Түүнийг Эрэгтэй хүнээс гаргаж авсан тул  
Эмэгтэй гэж нэрлэе хэмээн хэлжээ. ( Эхлэл 2:23 АБ 2004 )

[ ] Жинхэнэ хайр бол хамгийн агуу хүч гэдэгт та итгэдэг үү?

[ ] Бурхан яагаад Еваг дараа нь бүтээсэн гэдгийг та мэдэх үү?

[ ] Та хамгийн эхлээд Бурханд талархдаг уу?

## 8.7 УГИЙН БИЧГИЙГ ҮҮСГЭГЧ

### Үер ба хуваагдсан дэлхий

<sup>0</sup>Шемийн үр удам ийм болой. Шем зуун настайдаа буюу үер болсноос хойш хоёр жилийн дараа Арпахшадыг өрүүлжээ. <sup>11</sup>Тэрээр Арпахшадыг төрүүлснээс хойш таван зуу насалж, үр хүүхдүүдтэй олов. <sup>12</sup>Арпахшад гучин таван настайдаа Шелаг төрүүлжээ. <sup>13</sup>Тэрээр Селаг төрүүлснээс хойш дөрвөн зуун гуч насалж, үр хүүхдүүдтэй болжээ. <sup>14</sup>Шела гучин настайдаа Еберийг төрүүлэв. <sup>15</sup>Тэрээр Еберийг төрүүлснээс хойш дөрвөн зуун гурав насалж, мөн л үр хүүхдүүдтэй болжээ. <sup>16</sup>Ебер гучин дөрвөн настайдаа Пелегийг төрүүлэв. <sup>17</sup>Тэрээр Пелегийг төрүүлснээс хойш дөрвөн зуун гуч насалж, үр хүүхдүүдтэй болжээ. <sup>18</sup>Пелег гучин настайдаа Реуг төрүүлжээ. ( Эхлэл 11:10-18 АБ 2004 )

<sup>25</sup>Еберт хоёр хөвгүүн төрсөн бөгөөд нэг нь дэлхий хуваагдах тэр үед төрсөн учир түүнд Пелег гэдэг нэр өгчээ. Пелегийн дүүгийн нэр нь Иоктан болой. ( Эхлэл 10:25 АБ 2004 )

### Пелегээс Абрам хүртэл

<sup>19</sup>Реуг төрүүлснээс хойш тэрээр, хоёр зуун ес насалж, үр хүүхдүүдтэй болжээ. <sup>20</sup>Реу гучин хоёр настайдаа Серугийг төрүүлэв. <sup>21</sup>Серугийг төрүүлснээс хойш тэрээр хоёр зуун долоо насалж, үр хүүхдүүдтэй болжээ. <sup>22</sup>Серуг гучин настайдаа Нахорыг төрүүлжээ. <sup>23</sup>Тэрээр Нахорыг төрүүлснээс хойш хоёр зуу насалж, үр хүүхдүүдтэй болжээ. <sup>24</sup>Нахор хорин есөн настайдаа Тераг төрүүлэв. <sup>25</sup>Тэрээр Тераг төрүүлснээс хойш зуун арван ес насалж, үр хүүхдүүдтэй

болжээ. <sup>26</sup>Тера далан настайдаа Абрам, Нахор, Харан гурвыг төрүүлжээ. <sup>27</sup>Терагийн үр удам ийм болой. Тера нь Абрам, Нахор, Харан гурвыг төрүүлж, Харан нь Лотыг төрүүлжээ. <sup>28</sup>Харан нь эцэг Терагаас өмнө өөрийн төрсөн газар Халдеин Урт үхэв. <sup>29</sup>Тэгээд Абрам, Нахор хоёр эхнэр авцгаажээ. Абрамын эхнэр нь Сарай, Нахорын эхнэр нь Хараны охин Милка байв. Харан нь Милкагийн эцэг болон Искагийн эцэг болой. <sup>30</sup>Сарай хүүсэр эм байсан учир хүүхэдгүй байлаа. <sup>31</sup>Тера хүү Абрам, өөрийн ач хүү болох Хараны хүү Лот болон өөрийн бэр, Абрамын эхнэр Сарай нарыг авч, хамтдаа Халдеин Ураас Канаан нутгийг зорин хөдлөөд, Харанд ирж, тэндээ суужээ. <sup>32</sup>Тера хоёр зуун тав наслаад, Харанд үхэв ( Эхлэл 11:19-32АБ 2004 )

<sup>20</sup>Үүний дараа нэг нь -Милка чиний дүү Нахорт хүүхэд төрүүлж өгчээ гэж Абрахамд хэлжээ. <sup>21</sup>Түүний ууган хүү Уз, түүний дүү Буз, Арамын эцэг Кемуел, <sup>22</sup>Хесед, Хазо, Пилдаш, Иедлаф, Бетуел нар болой. <sup>23</sup>Бетуел нь Ребекаг төрүүлжээ. Милка Абрахамын дүү Нахорт эдгээр найман хүүхдийг төрүүлж өгчээ. <sup>24</sup>Нахорын татвар эм Реума гэгч Теба, Гахам, Тахаш, Маака нарыг төрүүлжээ. ( Эхлэл 22:20-24 АБ 2004 )

[ ] Бурхан хүн төрөлхтний ирээдүй хойч үеийг хадгалсан гэдэгт та итгэдэг үү?

[ ] Энэ угийн бичигт байгаа хүмүүсээс Абрамаас бусад нь хүүхэдтэй байсныг та мэдэх үү? Яагаад гэдгийг мэдэх үү?

[ ] Пелег гэдэг нь ямар утга учиртай болохыг мэдэх үү?

## 8.8 ОРЧЛОН ЕРТӨНЦИЙГ ТОГТООН БАРИХУЙ

*Бурхан од бүрийг нэрээр нь мэднэ*

<sup>25</sup>“Тэгвэл та нар Намайг хэнтэй адилтгаж, хэнтэй тэнцүүлэх вэ?” гэж Ариун Нэгэн айлдаж байна. <sup>26</sup>Нүдээ өндөрт өргөн тэдгээрийг хэн бүтээснийг харагтун. Тэдгээр оддын эздийг тоогоор нь авчрагч Нэгэн тэднийг бүгдийг нь нэрээр нь дууддаг юм. Түүний агуу их хүч, сүр жавхлангийн улмаас тэдгээрээс нэг нь ч алдагдаагүй. ( Иса 40:25-26 АБ 2004 )

[ ] Бурхан бүхнийг бүтээсэн бөгөөд өөр хэнд ч үүнийг хийх хүч байхгүй гэдэгт та итгэдэг үү?

## 8.9 ХАРАНХУЙ, ГАМШИГ, ГЭРЭЛ БА ХӨГЖЛИЙГ БҮТЭЭГЧ

*Гамигийг бий болгож, амьдралыг бүтээж хөгжлийг авчирдаг*

<sup>5</sup>Би бол ЭЗЭН.Өөр байхгүй.Надаас өөр Бурхан байхгүй. Хэдийгээр чи Намайг танихгүй ч,Би чамайг хүчирхэгжүүлнэ.  
<sup>6</sup>Тийнхүү Надаас өөр хэн ч байхгүй, Би бол ЭЗЭН, өөр байхгүй гэдгийг наран мандахаас наран шингэх зүг хүртэлх хүмүүс мэдэх болтугай! <sup>7</sup>Би гэрлийг буй болгон, харанхуйг бүтээж, энх амгаланг тогтоон, гай гамшгийг ч бүтээж байна. Би бол энэ бүгдийг хийдэг ЭЗЭН мөн. ( Иса 45:5-7 АБ 2004)

[ ] Ганц Бурхан байдаг гэдэгт та итгэдэг үү?

[ ] Та ерөөлүүд юу болохыг мэдэх үү?

## 8.10 БУРХАНТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ

Хэлсэн үг бол туйлын хууль юм; Бурханы хэлсэн үг бол үнэмлэхүй юм.

*Дуулгаваргүй байдал нь хараалыг авчирсан*

<sup>17</sup>Адамд хандан -Чи эхнэрийнхээ үгийг сонсож, “Бүү ид!” гэж миний чамд тушаасан модноос идсэн учир Чамаас болж газарт хараал хүрч, Чи насан туршдаа зүтгэж байж ургацыг нь идэх болно. <sup>18</sup>Газар чамд зангуу ба халгайг ургуулна. Чи тариалангийн талбайгаас ногоо идэх болно. <sup>19</sup>Чи газар шороондоо эргэж очих хүртлээ Духныхаа хөлсийг дуслуулан байж хоолоо олж иднэ. Учир нь чамайг газар шорооноос авсан. Чи тоос шороо тул тоос шороондоо буцаж очих болно гэжээ. ( Эхл 3:17-19АБ 2004 )

<sup>34</sup>Өөрийн гэрээг би зөрчихгүй, Амнаас гарсан авиагаа өөрчлөхгүй. ( Дуу 89:34 АБ 2004 )

[ ] Гуйвуулсан үгээр дамжин дайсан орж ирдэг гэдгийг та мэдэх үү?

[ ] Та тоос шороогоор биш үгээр амьдарч байна уу?

[ ] Адам яагаад эмэгтэйчүүдийн дуу хоолойг сонссоныг та мэдэх үү?